



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 01 сарын 21 өдөр

Дугаар 48

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д
давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх
тусгай зөвшөөрөл олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2.39 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосугай.

2. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн дүрмийн санд төсвөөс хуваарилсан мөнгөн хөрөнгийг даатгалын хууль тогтоомжийн шаардлага, 2014 оны Төсвийн тухай хуулийн зүйл ангийн дагуу байршуулж, ашиглах, компанийн бизнесийн тооцоо судалгаа, төлөвлөгөөнд суурилсан хөгжлийн загварыг гаргаж 2015 оны 1 дүгээр улиралд багтаан Хороонд ирүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Я.Өлзийболдод даалгасугай.

3. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж, даатгагч болон даатгуулагчийн хууль ёсны эрх ашгийг дээдлэн ажиллахыг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК /Я.Өлзийболд/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Ц.Энхбаяр/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА

000582